



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/321

Арвайхээр

Аймаг, сумын баяр наадмыг зохион
байгуулахгүй байх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7¹.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 171 дүгээр тогтоолын 3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (ковид-19)-ын орон нутаг дахь эрсдэлийн түвшин өндөр байгаа тул Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг аймаг, сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2.Аймгийн түүхт 90 жилийн ойн баяр наадамд зориулан төлөвлөсөн хөрөнгийг коронавируст халдвар (ковид-19)-ын хариу арга хэмжээний болон эмч, эмнэлгийн ажилтны урамшуулал, эрүүл мэндийн салбарт зарим шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зардалд шилжүүлэн зарцуулах төслийг боловсруулан шийдвэрлүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

3.Ардын хувьсгалын 100 жил, аймаг, сум байгуулагдсаны түүхт 90 жилийн ойгоо бүтээн байгуулалтын ажлаа эрчимжүүлэх замаар иргэдийнхээ амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, түүхэн хөгжил дэвшлийг залуу үедээ сурталчлан таниулах, салбар бүртээ ажил хөдөлмөрийн амжилт гарган угтахыг бүх шатны Засаг дарга, албан байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4.Хүн бүр хариуцлагатай байж, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан эрүүл мэндээ хамгаалж, эрхэлсэн ажил хөдөлмөртөө амжилт гарган түүхт ойдоо бэлэг барихыг аймгийн нийт иргэддээ уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100691

D:My Doc. Zahiramj. Zasag darga